



НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 11 сарын 04 өдөр

Дугаар 465

Улаанбаатар хот

Сургалт, семинар явуулах тухай

Монгол Улсын "Биеийн тамир, спортын тухай" хууль, Засгийн газрын 2009 оны 05, 2014 оны 34 дүгээр тогтоолууд, Нийслэлийн Засаг даргын 2013 – 2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн 2014 оны зорилтыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын байгууллагуудын удирдлага, ажилтнуудын дунд төрийн алба, ТАХ-ын холбогдолтой хууль тогтоомж, эрх зүйн сургалт семинарыг 2014 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулсугай.

2. Сургалт семинарыг зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, хичээл заах багш нарын бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Сургалт семинарт шаардагдах 460.000 /дөрвөн зуун жаран мянга/ төгрөгийг Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын төвлөрсөн төсвийн сургалт семинар, зөвлөгөөний зардлаас гаргахыг нягтлан бодогч О.Эрдэнэцэцэгт зөвшөөрсүгэй.

4. Сургалт семинарыг зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг ахлах мэргэжилтэн А.Болдмаад үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

1159500147